

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Ялгаатай хэрэгцээтэй оюутны боловсролын асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Даваабат Даваасүрэн

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Ялгаатай хэрэгцээтэй оюутны сургалтын агуулга, хөтөлбөр, үнэлгээ, хамгааллын асуудлаар баримтлах бодлого, эрх зүйн баримт бичиг, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах							
1	Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллага, их дээд боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй ялгаатай хэрэгцээтэй оюутныг суралцах, дасан зохицоход дэмжлэг үзүүлнэ.	Үйл ажиллагааны тоо, Хамрагдсан оюутны тоо	-	1 (үйл ажиллагааны тоо) 50 (хамрагдсан оюутны тоо)	1.Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн дэргэдэх Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн 6 оюутан, багш, ажилтан нийт 20 гаруй оролцогчид 2025 оны 05 сарын 08-ны өдөр Тотал Дистрибьюшин ХХК-аас санаачлан Боловсролын ерөнхий газар, Deaf club ТББ хамтран Сонсголын бэрхшээлтэй хүүхэд, оюутан залуусын бичгийн хэлний чадварыг нэмэгдүүлэх, бичгийн хэлийг сайн эзэмших хүсэл, тэмүүллийг нэмэгдүүлэх зорилгоор “Миний мөрөөдөл” эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулахтай холбоотой чиглүүлэх үүлзалтыг зохион	5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар	100%

					байгуулсан. 2.Идэр их сургуулиас зохион байгуулсан Polish up тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 15 өдөр зохион байгуулагдаж тус үйл ажиллагааны 2 дугаар шатанд хамтран оролцож, нийт 129 оюутан оролцсон үүний 14 нь хэл соёлын ялгаатай оюутнууд оролцсон. 3. Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад МУИС, МУБИС, ШУТИС, ХААИС, АШУУИС-ийн хөтөлбөр, онцлог, давуу талыг танилцуулах, сургуулиа сонгон суралцахад нь дэмжлэг үзүүлэх ажлыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр цахимаар зохион байгуулж уулзалтад Дотоодын 5 их сургуулийн удирдлага, мэргэжилтэн, тус аймгийн 5 багш, 32 суралцагчийг хамруулан мэдээлэл өгсөн. Нийт 3 үйл ажиллагааг зохион байгуулж 52 оюутныг оролцуулан өөрийн авьяас сонирхлыг илэрхийлэх, цаашид амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Хавсралт: 22 файл		
1.2. Ялгаатай хэрэгцээтэй оюутанд боловсролыг тэгш олгох боломж, орчин нөхцөлийг бүрдүүлэх							
2	Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын	Хамрагдсан оюутны тоо	12 (хамрагдсан оюутны тоо)	8 (хамрагдсан оюутны тоо)	1. Их, дээд сургуульд суралцаж буй хараа, сонсголын бэрхшээлтэй оюутанд зориулсан "Тэмдэглэл хөтлөгч"-	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р	100%

	байгууллагын ялгаатай хэрэгцээтэй оюутанд тэгш хүртээмжтэй суралцахад дэмжлэг үзүүлэх хүрээнд "Дохионы хэлний хэлмэрч, тэмдэглэл хөтлөгч" ажиллуулна.				ийн үйлчилгээг үзүүлэх ажлын хүрээнд 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс 5 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл МУИС-ийн 7 оюутны хичээлд 6 оюутан Тэмдэглэл хөтлөгчөөр ажилласан. Тус үйл ажиллагааны үр дүнд үйлчилгээнд хамрагдсан оюутан нь лекц, семинар, багшийн тайлбар, яриаг бичгээр бүрэн хүлээн авч, хичээлийн агуулгыг ойлгох, мэдээллийг хүртээмжтэй, тохируулгатай авч чадсанаар сурах арга барил нэмэгдэн, 1 оюутан хангалттай үнэлгээ авч шалгалтаас чөлөөлөгдсөн, нийт хамрагдсан оюутнууд амжилттай суралцах боломж бүрдсэн. Тэмдэглэл хөтлөгч оюутанд их, дээд сургуулийн оюутнууд сайн дурын ажил хийх “шинэ сонголт” бий болж тэмдэглэл хөтлөх, бичих чадвар сайжирч хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт, мэдээлэлтэй болон хүний эрхийг хүндэтгэх, бусдад нөлөөлөх мөн манлайлах чадвар нэмэгдэн 1 оюутан "Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулагч"-ийн ангид суралцсан үр дүнтэй ажил болсон. Тэмдэглэл хөтлөгчийн үйлчилгээ үзүүлж тэмдэглэл хөтлөгч оюутнууддаа саналыг хэлж, багш нарт тус үйлчилгээний мэдээллийг өгч, үйлчилгээг сайжруулсан. 2.	сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	---	--	--	--	---	--	--

					“Боловсролын Дэлхийн Түншлэл” Олон улсын байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Тэгш боломжийг бүрдүүлэх замар суралцахуйг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Сонсголын бэрхшээлтэй сурагчдад зориулсан туслах хэрэглэгдэхүүний тохируулга хийх” зөөврийн компьютер (Chromebook) 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын яаманд гардуулан өгөх үйл ажиллагаа болсон. Хараа, сонсголын бэрхшээлтэй МБТБСБ мөн Их, дээд сургуулийн оюутны судалгааг гарган өгч, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Монгол улсын их сургууль, Монгол улсын боловсролын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургуульд нийт 22 компьютер (Chromebook) олгосон. Хавсралт: 16 файл		
3	Эцэг эх, олон нийтэд тэгш хамруулах боловсролын чиглэлээр эерэг хандлагыг бий болгох зурагт хуудас, бичлэгийг бэлтгэн түгээн	Зохион байгуулсан нөлөөллийн ажлын тоо, Бэлтгэсэн зурагт хуудас эсвэл бичлэгийн тоо	1 (зохион байгуулсан нөлөөллийн ажлын тоо) 6 (бэлтгэсэн зурагт хуудас эсвэл бичлэгийн тоо)	1 (зохион байгуулсан нөлөөллийн ажлын тоо) 3 (бэлтгэсэн зурагт хуудас эсвэл бичлэгийн тоо)	1. Суралцагчийн амралттай холбоотой олон нийт, эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэл бэлтгэн хүргэх хүрээнд зурагт хуудсыг видео хэлбэрээр бэлтгэсэн. Тус видеог БЕГ цахим хуудсанд 1 дүгээр сарын 10-ны өдөр 1 видео хэлбэрээр бэлтгэн байршуулж 72 хандалт,	1-р сар, 2-р сар, 4-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 11-р сар	100%

	дэлгэрүүлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.				111 хүн хуваалцсан. 2. Эцэг ах, асран хамгаалагчдад зориулсан “Хүүхдийн хөгжлийг дэмжих” сэдэвт богино бичлэгийг бэлтгэн 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдөр БЕГ-ын цахим хуудсанд байршуулж 166 хандалт, 305 хүн хуваалцсан. 3. “Дэлхийн даун синдромтой хүмүүсийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулан 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр БЕГ-ын цахим хуудсанд байршуулж 70 хандалт, 32 хүн хуваалцсан. Суралцагчийн амралтаа үр дүнтэй өнгөрүүлэхтэй холбоотой олон нийт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч таны үүрэг, оролцоо мөн “Хүүхдийн хөгжлийг дэмжих”, Даун синдром сэдвийн хүрээнд 1 зурагт хуудас, 2 видео бэлтгэн нийт 308 хандалт, 448 хүн хуваалцсан. Тус үйл ажиллагааны үр дүнд оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн. Хавсралт: 7 файл		
1.3. Ялгаатай хэрэгцээтэй оюутантай ажиллаж буй багш, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад хамруулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах							
4	Тусгай хэрэгцээт боловсролын багшийг гадаадын их, дээд сургуулийн мэргэшүүлэх хөтөлбөрт хамруулах түүнтэй	Гүйцэтгэлийн хувь, Хамруулсан суралцагчийн тоо	-	50 (гүйцэтгэлийн хувь)	Оросын холбооны улсын Чита хотын Өвөрбайгалийн их сургуульд “Тусгай хэрэгцээт боловсрол”-ын багшаар бакалавр, магистрын хөтөлбөрт 15 хүнийг ТЭТГЭЛЭГ-тэй суралцах чиглэлээр сонгон	2-р сар, 6-р сар, 8-р сар, 12-р сар	100%

	холбоотой ажлыг бэлтгэл ханган ажиллана.				шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулж Өвөрбайгалийн их сургуульд үр дүнг хүргүүлэх тухай БЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/308 дугаар албан бичгээр үр дүнг хүргүүлсэн. Тус сонгон шалгаруулалтын 1 дүгээр шатанд 34 иргэн оролцож үүний 26 оролцогчийг 2 дугаар шатны шалгаруулалтад оролцуулж 2 иргэнийг бакалавр, 13 иргэнийг магистрын хөтөлбөрт элсүүлэхээр холбогдох баримтыг бүрдүүлэн илгээсэн. Хавсралт: 11 файл		
5	Ялгаатай хэрэгцээтэй оюутантай ажиллаж буй багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан багшийн тоо	-	25 (сургалтад хамрагдсан багшийн тоо)	1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 51 удирдлага, Боловсролын газрын 10 мэргэжилтэн нийт 61 албан хаагчид "Тэгш хамруулах боловсрол"-ын талаарх сургалтыг цахим хэлбэрээр 5 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Тус үйл ажиллагааны үр дүнд МБТБСБ-ын удирдлагууд хууль, эрх зүйн орчны талаарх мэдээлэл, сургалтын хүртээмжтэй орчин, хэрэглэгдэхүүний талаарх холбогдох журам, оюутнуудад чиглэн хийгдсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэлтэй болсон. Ерөнхий боловсролын чиглэлээр	4-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					нэмэлтээр дараах сургалтуудыг зохион байгуулсан. 1. Нийслэлийн Монгол – Оросын хамтарсан дунд сургууль, Нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” сургуульд “Тэгш хамруулах боловсрол”-ын арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 10, 18-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад "Дэмжлэгийн багийн үүрэг, оролцоо сэдвээр багш, удирдах ажилтан, нийт 274 албан хаагчийг хамруулан мэдлэг, ойлголт өгч ажилласан. 2. Төв аймгийн боловсролын байгууллагын удирдлагуудад 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр “Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах, дэмжлэгийн багийн үүрэг оролцоо, хамтын ажиллагаа мөн Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдвээр мэдээлэл бэлтгэн танилцуулав. Сургалтад Төв аймгийн ЕБС-ийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч нарын төлөөлөл 52 албан хаагч хамрагдаж Дэмжлэгийн багийн үүрэг, үйл ажиллагаа мөн Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргад суралцсан. 3. Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн	
--	--	--	--	--	--	--

					удирдлага, бага ангийн багш нарт 2 дугаар сарын 13, 19-ний өдрүүдэд нийт 40 багшид Хараа, Сонсгол, Хөдөлгөөн, Оюуны бэрхшээл, Даун, Аутизмын хүрээний эмгэгтэй суралцагчтай ажиллах арга зүй сэдвүүдээр агуулга бэлтгэн сургалтыг цахимаар зохион байгуулсан. Үйл ажиллагааны үр дүнд ХБ-ийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдэж багш нар ХБ-тэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээ сайжруулсан. Хавсралт: 27 файл		
6	Ялгаатай хэрэгцээтэй оюутантай ажиллаж буй сургалтын байгууллагын удирдлага багш ажилтан, мэргэжилтнүүдэд зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.	Зөвлөн туслах үйл ажиллагаад хамрагдсан хүний тоо	5 (зөвлөн туслах үйл ажиллагаад хамрагдсан хүний тоо)	20 (зөвлөн туслах үйл ажиллагаад хамрагдсан хүний тоо)	1. Багшлах эрхийн гэрчилгээ олгох сургалтыг МУБИС, СЭЗИС, ОУУБИС, Отгонтэнгэр их сургуулиуд цахим болон танхим хосолсон хэлбэрээр 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан. БЕГ-аас журмын хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын хэсэг байгуулах А/375 дугаар тушаал, 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр удирдамж гарган сургалтын үйл явцтай танилцах суралцагчдыг баталгаажуулах, суралцагчдын саналыг сонсох, төгсөлтийн гэрчилгээг бэлтгэх ажлыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд Отгонтэнгэр их сургуульд 1 дүгээр сарын 10 нд 7 оюутан багш, 3 багш, удирдлага, СЭЗИС-д 1 дүгээр сарын 15-ны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					өдөр 23 оюутан багш, 3 багш, удирдлага нийт 36 оюутан багш, албан хаагчдад тус тус зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, журмын хэрэгжилтийг ханган ажилласан. 2. МУИС-д тэмдэглэл хөтлөгчийн үйлчилгээ авч буй болон үйлчилгээ үзүүлж буй 7 оюутан, 5 багш, ажилтан нийт 12 хүнийг хамруулан 2025 оны 5 дугаар сарын 5-8-ны өдрүүдэд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үйл ажиллагаагаар тэмдэглэл хөтлөгч оюутнаас хичээлийн лекц агуулгыг хүлээн авч чадаж буй эсэх саналыг сонсож тэмдэглэл хөтлөгч оюутнууддаа саналыг хэлж, багш нарт тус үйлчилгээний мэдээллийг өгч, үйлчилгээг сайжруулсан. 3.МБТБСБ-ын (Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төвийн Мэргэжлийн боловсрол ур чадвар олгох сургууль, Үйлдвэр урлалын политехникийн коллеж) 2 байгууллагад зөвлөн туслах үйл ажиллагааны удирдамжийн хүрээнд 2025 оны 5 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд нийт 19 багш, ажилтанд ялгаатай хэрэгцээтэй суралцагчид чиглэсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх, Сургалтын хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын	
--	--	--	--	--	---	--

					орчин, нөхцөл, туслах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй хэлбэрээр бүрдүүлэх чиглэлийг сургалтын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаарх зөвлөгөө өгч, зөвлөмж боловсруулан ажилласан. Хавсралт: 19 файл		
7	Ялгаатай хэрэгцээтэй оюутныг боловсролын үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй хамруулах чиглэлээр төр, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	Хамтран ажилласан байгууллагын тоо	5 (хамтран ажилласан байгууллагын тоо)	1 (хамтран ажилласан байгууллагын тоо)	1. "Тэгш оролцоот ээлтэй нийгэм" ТББ-тай хамтран "Бидний мэдэх Брайл" эсээ бичлэгийн уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж Төр, хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулийн 83, МБТБ, их, дээд сургуулийн – 44, нийт 127 суралцагч нэгдүгээр шатанд оролцож, хоёрдугаар шатанд ЕБС-ийн насны ангилалд 22 суралцагч, МБТБ, их, дээд сургуулийн насны 10 оюутан нийт 32 оролцогч танхим болон цахимаар эсээг өөрсдөө танилцуулан хэлэлцүүлж, ангилал тус бүр шагналт 5 байрыг шалгаруулан Өргөмжлөл, талархал гардуулсан. 2 дугаар шатны шалгаруулалтыг 3 дугаар сарын 25-ны өдөр Монголын үндэсний номын санд зохион байгуулсан. Энэхүү эсээ бичлэгийн уралдааны оролцогчдын 90 хувь	5-р сар, 8-р сар, 11-р сар	100%

					нь ердийн ЕБС-ийн суралцагчид хамрагдаж буй нь дунд болон ахлах ангийн суралцагчдын хандлагад эергээр нөлөөлж буйг харуулж байгаа юм. 2.“Оюутны хөгжлийн цогц бодлого-Асуудал, шийдэл” хэлэлцүүлгийг 4 дүгээр сарын 17-ны өдөр МУИС-тай хамтран төрийн ордонд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн 700 удирдлага, багш, оюутны төлөөллийг оролцуулсан. Тус хэлэлцүүлгээр БЕГ-аас хэрэгжүүлж буй “Тэмдэглэл хөтлөгч”-ийн үйлчилгээг оролцогчдод танилцуулан, дээд боловсролын сургалтын байгууллагын оюутны хөгжил, үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгох талаарх оюутнуудын саналыг сонсож, зөвлөмжид тусгуулахаар саналаа хэлэлцэв. 3.“Боловсролын тэгш хүртээмж” хэлэлцүүлгийг 4 дүгээр сарын 29-ний өдөр ХБХХЕГ, БЗС-тай хамтран зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт төр, ТББ-ын оюутны төлөөлөл 40 хүн хамрагдсан. Тэгш хамруулах боловсролын бодлогын хэрэгжилт Боловсролын төрийн сангийн зээлд хамрагдагчдын асуудал, Их дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр болон боловсролын зээлийн санд хамрагдсан оюутнуудын хөгжил оролцоо, Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн цаг	
--	--	--	--	--	--	--

					хугацааны талаарх мэдээлэл, МУИС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг дэмжиж буй сайн туршлага сэдвийн хүрээнд мэдээлэл нэмэгдэн мөн оюутнуудын тулгамдаж буй асуудлын хүрээнд асуулт, хариулт өрнүүлж, санал, хүсэлтийг нь сонссон. Хавсралт: 17 файл		
--	--	--	--	--	---	--	--

3.1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх

8	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулна.	Гүйцэтгэлийн хувь	100% (гүйцэтгэлийн хувь)	100% (гүйцэтгэлийн хувь)	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, Их, дээд сургуулийн ялгаатай хэрэгцээтэй оюутныг тэгш хамран сургах бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил мөн Тендерийн баримт бичиг бүхий 2 хадгаламжийн нэгжийг архивлан хүлээлгэн өгсөн. Хавсралт: 4 файл	1-р сар, 2-р сар	100%
9	Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурал, Суралцагчийн хөгжлийн газрын шуурхай хурал, Тэгш хамруулах хэлтсийн шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын	Хуралд оролцсон тоо, Үүрэг даалгаврын биелэлтийн хувь	10(хуралд оролцсон тоо) 100% (үүрэг даалгаврын биелэлтийн хувь)	4(хуралд оролцсон тоо) 100%(үүрэг даалгаврын биелэлтийн хувь)	Суралцагчийн хөгжлийн газрын 5 шуурхай хуралд оролцож Эцэг эх, олон нийтэд чиглэсэн 3 видеог бэлтгэн БЕГ-ын цахим хуудаст нийтэлж цаг тухай бүрд нь үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан. Тэгш хамруулах боловсролын хэлтсийн хуралд 2 удаа оролцож даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу Япон улсад туршлага судалсан ППТ	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р	100%

	хэрэгжилтийг хангаж ажиллана.				бэлтгэн холбогдох газрын дарга, мэргэжилтэн 9 албан хаагчид мөн Боловсролын сайдын 2025 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/196 дугаар тушаалыг Боловсролын газрын дарга, мэргэжилтнүүдэд танилцуулах ППТ бэлтгэн 05 дугаар сарын 27-ны өдөр нийт 134 албан хаагчдад тус тус танилцуулсан. Нэгжийн даргын үүрэг болгосноор Боловсролын сайдын 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/58 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 оны 2 дугаар сарын 21, 26-ны өдөр зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, тайланг нэгтгэн ажилласан. Хавсралт: 15 файл	сар	
--	-------------------------------	--	--	--	--	-----	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх

1	Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар болон холбогдох дээд шатны байгууллагаас зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдана.	Хамрагдсан үйл ажиллагааны тоо	5 (хамрагдсан үйл ажиллагааны тоо)	2 (хамрагдсан үйл ажиллагааны тоо)	1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагааны сонсгол 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулагдсан. Сонсголын үеэр танилцуулсан ажлын гүйцэтгэл, үр дүн, саналд үндэслэн цаашид тухайн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлөөс зөвлөмж, албан даалгаврыг хэлэлцэн баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтэд анхаарч ажиллана. 2.Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалыг танилцуулах уулзалтад 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр оролцсон. Тус уулзалтад хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам танилцуулсан. Тус журмын хүрээнд Тэгш хамран сургах боловсролын мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан. 3.Боловсролын салбарт хүний нөөцийн чиглэлээр ажиллаж буй албан хаагчид болон залуу боловсон хүчний төлөөллөөс бүрдсэн боловсролын салбарын	2-р сар, 4-р сар, 6-р сар, 8-р сар, 10-р сар, 12-р сар	100%
---	---	--------------------------------	------------------------------------	------------------------------------	--	--	------

					хүний нөөцийн “EDU-HR” клубт гишүүнээр элсэн. “EDU-HR” клуб 2025 оны 04 дүгээр сарын 21-нд анхны хурлаа зохион байгуулж, хурлаараа салбарын болон байгууллагын хэмжээнд албан хаагчдад тулгарч буй нийтлэг асуудлуудын талаар санал солилцож, хүний нөөцийн чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө хэлэлцсэн. Клуб нь хүний нөөцийн орчин үеийн хандлагаас суралцаж, харилцан мэдлэг, туршлага солилцох, байгууллагын болон салбарын албан хаагчдын ур чадварыг хөгжүүлэх, байгууллагын соёл, ажилтны сэтгэл ханамж, ажлын бүтээмжийг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажил хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан. 4. БЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/396 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралд 3 удаа оролцон үйл ажиллагааны зохион байгуулалт хийж, ажлын хэсэгт ажилласан. Хавсралт: 18 файл		
2	Тэгш хамруулах боловсролын хүрээнд арга зүйн чиглэлээр гадаад, дотоодод, урт, богино хугацааны сургалтад	Хамрагдсан сургалтын тоо	10 (хамрагдсан сургалтын тоо)	2 (хамрагдсан сургалтын тоо)	1. Япон улсын Тусгай хэрэгцээт боловсролын хүрээлэн NISE (National Institute of Special Needs Education), Цүкүба их сургуулийн дэргэдэх Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдэд зориулсан тусгай	4-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар	100%

	хамрагдана.				Цэцэрлэг, Бага сургуулийн үйл ажиллагаатай танилцан 2025 оны 04 дүгээр сарын 24-25 ны өдрүүдэд туршлага судалж тус газруудын мэдээллийг ППТ-гээр бэлтгэн холбогдох дарга мэргэжилтэн 9 албан хаагчид танилцуулсан. 2. Боловсролын яамнаас "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-тэй хамтран боловсролын байгууллагын холбогдох зарим албан хаагчдад "Монгол дохионы хэлний харилцааны анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалт"-ыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 2-ны өдрүүдэд зохион байгуулж. Тус сургалтад хамрагдаж Монгол дохионы хэлний харилцааны анхан шатны мэдлэг, чадвар эзэмшин, Батламж гардан авсан. 3. Австралийн Засгийн газрын санхүүжилттэй Австралийн сайн дурын хөтөлбөрийн хүрээнд Австралийн сайн дурын ажилтан Сонсголгүйн Боловсрол ТББ-тай хамтран зохион байгуулж буй 6-р сарын 2-ны өдрийн "Сонсголгүйн сэтгэцийн эрүүл мэнд", 6-р сарын 4-нд зохион байгуулагдах "Эрт оролцоо ба Сонсголгүйн боловсрол" сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтуудад хамрагдаж сонсголгүй хүүхдүүдтэй ажилладаг багш, эцэг эх, иргэний нийгэм, төрийн байгууллагын төлөөллүүд		
--	-------------	--	--	--	---	--	--

					идэвхтэй оролцсон нь олон талын ойлголцол, хамтын шийдэлд хүрэх чухал алхам болсон. Хавсралт: 15 файл		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ялгаатай хэрэгцээтэй оюутны боловсролын асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Даваабат Даваасүрэн

/...../

Огноо: